

ПҮРЭВДОРЖ ОВОГТОЙ ЧУЛУУНХҮҮ

ТОВЧ НАМТАР, АЖИЛ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Пүрэвдорж овогтой Чулуунхүү нь 1989 оны 8 дугаар сарын 09-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд сумын айлын 3 хүүхэд болон мэндэлсэн. Ам бүл [REDACTED] амьдардаг.

П.Чулуунхүү нь 1997 онд Дорноговь аймгийн Сайншанд сумын 10-н жилийн Ерөнхий боловсролын дунд сургуульд элсэн суралцаж төгссөн. 2008-2012 онд Тайланд улсын Rangsit Их сургуулийг Бизнесийн удирдлагаар баклаварын зэрэгтэй төгссөн. 2018 - 2020 онд Улаанбаатар хотын Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуульд Бизнес удирдлагын чиглэлээр суралцаж Магистрын зэрэг хамгаалсан.

П.Чулуунхүү нь 2010 оноос ажлын гараагаа “Болдтөмөр Ерөө Гол” ХХК-д Эдийн засагч албан тушаалд ажиллаж эхэлсэн. Ажиллаж байх хугацаандаа уул уурхайн салбарын эдийн засгийн тооцоолол, Санхүү Татварын тооцооллыг амжилттай хийж хэрэгжүүлэн ажилласан тул 2013 оны 5 дугаар сараас эхлэн Ахлах эдийн засагч болж тушаал дэвшсэн.

Мөн 2016 оны 7 дугаар сараас эхлэн “Болдтөмөр Ерөө Гол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон одоог хүртэл ажиллаж байна. Тус компанийн удирдлагаар ажиллаж байгаа энэ хугацаандаа хэд хэдэн томоохон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс дурьдвал: Ажилчдынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд анхаарч ажиллаж, амрах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор уурхайчдын хотхоныг шинэчлэн тохижуулж, олон улсын стандарт хангасан орчин үеийн уурхайн цогцолбор хотхонг байгуулсан. Уул уурхайн чиглэлийн компани хэдий ч өнгөрсөн он жилүүдэд улс орныхоо төмөр замын салбарын хөгжилд хувь нэмэр оруулсан тодорхой төслүүдийн нэг болох Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт 12 км төмөр замыг байгуулах ажлыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн боловсруулсан зураг төслөөр дөрвөн сарын хугацаанд амжилттай гүйцэтгэсэн. Мөн Герман, Орос, Хятадын дэвшилтэд технологийн тоног төхөөрөмж бүхий Хөдлөх бүрэлдэхүүний засварын депо байгуулж 2019 онд ашиглалтад оруулсан. Улсын хэмжээнд ачааны вагон засвар үйлчилгээний хоёр дахь депо учир ачааны вагон засварлах өнөөгийн хүчин чадлыг тодорхой хувиар нэмэгдүүлсэн ач холбогдолтой төсөл юм.

2019 оноос Монгол улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа “Алтанширээт Аж үйлдвэрийн парк” төслийн удирдлагчаар ажиллаж байна. Энэхүү төсөл нь хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргахаар зорин ажиллаж байна.

П.Чулуунхүү нь Монголын Төмөрлөг Үйлдвэрлэгчдийн Холбооны Удирдах Зөвлөлийн даргаар 2020 оны 5 дугаар сард томилогдсон. Энэхүү сонгуульт ажлын хугацаандаа төмөрлөг үйлдвэрлэлийн чиглэлээр олон ажил санаачлан хэрэгжүүлэх, хүнд үйлдвэрийн салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.